



СОЁЛЫН ЯАМ



СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2020 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

АГУУЛГА

- “2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 29 (+1) арга хэмжээний товч танилцуулга
- Тулгарч буй хүндрэл бэрхшээл
- Дүгнэлт, хэтийн зорилго, (шинэлэг санаа) санал
- 2015-2020 оны Санхүүгийн мэдээлэл


Г.Энхбат. Соёлын өвийн үндэсний
төвийн захирал

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.3 дахь заалт

Соёлын өвийн үндэсний төв нь Монгол Улсын соёлын өвийг бүртгэх, мэдээлэх, авран хамгаалах чиг үүрэг бүхий соёл, эрдэм шижилгээний байгууллага байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/295 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ



**СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2020 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ
МЭДЭЭЛЭЛ**

№	Хэсэг	2020 оны төлөвлөгөөт арга хэмжээний тоо	Хэргэжсэн	Үнэлэх боломжгүй	Нэг бүрийн хувь
1.	1.	1.1.1. ЮНЕСКО-ийн Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өв-Лимбэний битүү амьсгааг хамгаалах ажлын II үе шатыг хэрэгжүүлэх	*		100
2.		1.2.1. “Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөр-2020 төлөвлөгөөний 2.1.2, 2.1.4-д дурдсан дурсгалаас хэв, дардсыг авах, хуулбар хийж хадгалах		*	
3.		1.2.2. “Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөр-2020 төлөвлөгөөний 2.1.1, 2.2.3, 2.2.7-д дурдсан дурсгалыг цэвэрлэж, бэхжүүлэх. (сэргээн засварлах)		*	
4.		1.2.3. “Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөр-2020 төлөвлөгөөний 1.2.1, 1.2.4 дэх бүтээгдэхүүн баруун болон зүүн бүсийн соёлын өвийг бүртгэн баримтжуулах хээрийн судалгаа хийх.		*	
5.		1.2.4. Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөр-2020 төлөвлөгөөний 1.3. Зарим томоохон цогцолбор дурсгалын оршин буй газрыг кадастрын улсын бүртгэлд бүртгүүлэх.	*		90
6.		1.2.5. “Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөр-2020 төлөвлөгөөний 2.4.1, 2.4.3-д дурдсан устах эрсдэлд орсон дурсгалыг аюулгүй газарт шилжүүлэн байршуулах.	*		100
7.		1.2.6. Соёлын өвийг аврах, хамгаалах, ашиглах үндэсний сүлжээг төгөлдөржүүлэх, “Чулуун соёлын өв”, БСШУС-ын сайдын 2019 оны А/368 дугаар тушаал, төлөвлөгөөний 2.3.1, 2.3.2, 2.3.3, 2.3.6 дахь бүтээгдэхүүнийг хэрэгжүүлэх.	*		95
8.		1.3.1. “Соёлын биет бус өвийн үндэсний хөтөлбөр”-2020 төлөвлөгөөн дэх 2.1.2, 2.1.3 дахь арга хэмжээг хэрэгжүүлэх. -Соёлын биет бус өвийн үзлэг зохион байгуулахад хамтран оролцох. -Баруун бүсийн (Баян-Өлгий аймаг) соёлын биет бус өвийн суурь судалгаа, гэрэл зураг, дуу дүрс бичлэгээр баримтжуулах.		*	
9.	2.	2.1.1. Соёлын өвийн талаар иргэдэд өгөх мэдээллийг цахим орчинд, хурдан шуурхай, чирэгдэлгүй хүргэх.	*		100
10.		2.1.2. Аж ахуйн нэгж, байгууллагад өгөх лавлагаа, мэдээллийг хурдан шуурхай, хүнд сурталгүй, авлигаас ангид хүргэх.	*		100
11.	3.	3.1.1.1. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, археологийн олдвор эд зүйлийг бэхжүүлэх, сэргээн засварлах.	*		100
12.		3.1.1.2. Шороон бумбагарын дурсгалт газрын ханын зургийн цэвэрлэгээ, судалгааны ажлыг зохион байгуулав.	*		100
13.		3.1.1.3. Соёлын өвийг хамгаалахад химийн бодисын эрэлт хэрэгцээ, хэрэглээ, ашиглалтын сүлжээ бий болгох.		*	

№	Хэсэг	2020 оны төлөвлөгөөт арга хэмжээний тоо	Хэргэжсэн	Үнэлэх боломжгүй	Нэг бүрийн хувь
14.	3.	3.1.2.1. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн 2018-2019 оны улсын тооллогын мөрөөр авах арга хэмжээ.		*	
15.		3.1.2.2. Цаасан болон цахим суурьтай соёлын өвийн мэдээллийг Соёлын өвийн үндэсний төвийн шинэ байр руу нүүлгэн шилжүүлэх.		*	
16.		3.1.2.3. Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн цаасан болон цахим архивыг төгөлдөржүүлэх.	*		100
17.		3.1.2.4. Соёлын биет болон биет бус өвийн дүрс бичлэг, гэрэл зургийн мэдээллийн сан бүрдүүлэх.	*		100
18.		3.1.2.5. Соёлын өвийн мэдээллийн сангийн цахим сүлжээ байгуулан ажиллах, байгууллага, олон нийтэд, мэдээллийг түгээх.	*		100
19.		3.1.2.6. Улаанбаатар хотод байрлах улсын музейн гадаад, дотоод орчны хадгалалт хамгаалалт ба соёлын өвийн БМСангийн бүрдүүлэлтэд арга зүйн зөвлөгөө өгөх	*		60
20.		3.1.3.1. “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого-2020” зохион байгуулахад хамтран оролцох.		*	
21.		3.1.3.2. МБШТөв Гандантэгчэнлин хийдэд хадгалагдаж буй бурхан шүтээн, эд өлгийн зүйлийн улсын тооллого”-ыг зохион байгуулахад хамтран оролцох.(нэмэлт ажил)	*		95
22.		3.1.4.1. Соёлын өвийг сурталчлах, мэдлэг олгох.	*		100
23.		3.2.1.1. Үндэсний төвийн орон тоо, бүтцийг боловсронгуй болгох	*		100
24.		3.2.1.2. Ажилтнуудын мэдлэг боловсролоо дээшлүүлэх, ахисан шатанд суралцах, ур чадвараа ахиулах сонирхлыг дэмжиж боломж нөхцөлөөр хангах, зохих сургалтанд хамруулах	*		100
25.		3.2.2.1. Нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын хэрэгжилт дээр хяналт хийх.	*		70
26.		3.2.2.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, ажлын байранд хийсэн шинжилгээ, зохих байгууллагаас өгсөн үүрэг даалгавар, хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэнд шалгалт хийх.	*		100
27.		3.2.2.3. Төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдлийн удирдлагаар хангах.	*		100
28.		3.2.2.4. Ашиг сонирхлын зөрчил, авлигатай тэмцэх үйл ажиллагаа, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах.	*		100
29.	3.2.2.5. Төрийн албан хэрэг хөтлөлт, архив, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын бүрдэлд тавих хяналт	*		100	
30.	3.2.2.6. Онцгой байдал, гамшигтай тэмцэх үйл ажиллагаанд тавих хяналт.	*		100	
Нийт 30(29+1)			22	8	95,9



НЭГДҮГЭЭР ХЭСЭГ.

БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ


№	Үндсэн чиг үүрэг	Зорилтын тоо	Төлөвлөгөөт арга хэмжээний тоо	Хэрэгжсэн арга хэмжээний тоо	Хэрэгжээгүй арга хэмжээний тоо	Гүйцэтгэл
1.	ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ №1.1. ЮНЕСКО-ИЙН СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ХАМГААЛАХ КОНВЕНЦЫН 11 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ	1	1	1		100
2.	ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ №1.2. “ЧУЛУУН СОЁЛЫН ӨВ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР-2020 ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ	1	6	3	3 (санхүү, ковид-19)	95
3.	ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ №1.3 “СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР”-2020 ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ	1	1		1 (санхүү, ковид-19)	Үнэлэх боломжгүй
Нийт		3	8	4	4	97,5 хувь

ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ №1.1. ЮНЕСКО-ИЙН СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ХАМГААЛАХ КОНВЕНЦЫН 11 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.1-р арга хэмжээ

ЮНЕСКО-ийн Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өв-Лимбэний битүү амьсгааг хамгаалах ажлын II үе шатыг хэрэгжүүлэх.

- Дунд шатны шавь сургалт: мониторинг, (Зүүн баруун бүс): 6400 км, 9 багш, 40 шавь сурагч, (10 эмэгтэй), 9,4 цагийн дүрс бичлэг, 94 гэрэл зураг, 108.7 MB цахим сан,
- “Монгол Лимбэний урлаг” номын эх бэлтгэх, CD,
- “Монгол лимбэчдийн уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгаа” Баримтат киноны эх бэлтгэх ажил 70% (2020 онд дуусгана)
- Сурталчилгаа: Соён гэгээрүүлэх телевиз (2 улирал)
- “Соёлын биет бус өвийн талаарх мэдлэг, ойлголтыг ерөнхий боловсролын сургуулийн сургалтын агуулгад нэвтрүүлэх боломж, шийдэл” уулзалт Соёлын яам, ЮНЕСКО-гийн МҮК, түүний холбоо 8 сургуулийн төлөөлөл
- Шинэ байрны лимбэний танхимын тохижилт: акустик хавтан, нотны тавиур.



**ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ №2.1. “ЧУЛУУН СОЁЛЫН ӨВ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР-2020
ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:**

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1-р арга хэмжээ

“Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөр-2020 төлөвлөгөөний 2.1.2, 2.1.4-д дурдсан дурсгалаас хэв, дардсыг авах, хуулбар хийж хадгалах.

2020 онд 2 дурсгалт газар үүнд, Хэнтий аймгийн Рашаан хадны тамгат хавтан, Архангай аймгийн Дадгийн өвөлжөөний хүн чулууд хамрагдана.

-2 удаа газар дээр нь очиж судалгаа хийнэ.

-Хөтөлбөрийн хүрээнд 2019 онд 3 дурсгалт газраас хэв авч хуулбар хийсэн бол 2020 онд 2 дурсгалт газраас 3 хэв нийт 5 дурсгал болж нэмэгдсэн байна.

Арга хэмжээ зохион байгуулахад шаардагдах санхүүгийн тооцоог гарган дээд удирдах шатны байгууллагад хүргүүлсэн боловч боловч санхүүжилт шийдэгдээгүй.

Албан бичгийн дугаар: 2020 оны 4 дүгээр сарын 02-ны 01/116 тоот. (БСШУ-ны дэд сайдад)

Үнэлэх боломжгүй.






Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.2-р арга хэмжээ

“Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөр-2020 төлөвлөгөөний 2.2.1, 2.2.3, 2.2.7-д дурдсан дурсгалыг цэвэрлэж, бэхжүүлэх. (сэргээн засварлах)

- Архангай аймгийн Их тамир сумын Тайхар чулуу, Хархорумын мэлхий хөшөө дурсгалт газар ажиллав.



- Үндэсний хөтөлбөр бүрэн санхүүжилтгүй
- Төрийн бус байгууллагын санхүүжилтээр бохирдол, гэмтлийн судалгаа хийсэн



Үнэлэх боломжгүй.

БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.3-р арга хэмжээ

“Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөр-2020 төлөвлөгөөний 1.2.1, 1.2.4 дэх бүтээгдэхүүн баруун болон зүүн бүсийн соёлын өвийг бүртгэн баримтжуулах хээрийн судалгаа хийх.

- Арга хэмжээ зохион байгуулах удирдамж, маршрут, үйл ажиллагаа, төсвийг боловсруулан “Чулуун дурсгалын бүртгэн баримтжуулалт” төслийг БСШУСЯ-ны Соёл, урлагийн бодлогын зохицуулалтын газарт 2020 оны 04 сарын 03-ны өдрийн 01/117 тоот албан бичгийн хавсралтаар хүргүүлсэн.
- БСШУС-ын Сайдын А/175 тоот тушаал гарсан боловч санхүүжилт олгогдоогүй.


Үнэлэх боломжгүй.

БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ


Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.4-р арга хэмжээ

Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөр-2020 төлөвлөгөөний 1.3. Зарим томоохон цогцолбор дурсгалын оршин буй газрыг кадастрын улсын бүртгэлд бүртгүүлэх.


- Нийт 4 дурсгалт газарт хамгаалалтын бүс тогтоох кадастрын хэмжилт судалгаа хийгдсэн. (Бусад салбарын байгуулагатай харилцан ажиллаж байж КАДАСРТЫН БҮРТГЭЛ болно)




1. Дундговь аймгийн Дэл уулын хадны зураг бүхий цогцолбор 20 эргэлтийн цэг, 44153.6 га талбай.



3. Дорнод аймгийн Их бурханы цогцолбор 7 эргэлтийн цэг, 683.8 га талбай.




2. Хэнтий аймгийн Сэрвэн хаалганы бичээс 6 эргэлтийн цэг, 9167 га талбай.



4. Сүхбаатар аймгийн Хаалгатын хүн чулуу 9 эргэлтийн цэгийн байршил 3557 га талбай,

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.4-р арга хэмжээ

Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөр-2020 төлөвлөгөөний 1.3. Зарим томоохон цогцолбор дурсгалын оршин буй газрыг кадастрын улсын бүртгэлд бүртгүүлэх.



БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.5-р арга хэмжээ

“Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөр-2020 төлөвлөгөөний 2.4.1, 2.4.3-д дурдсан устах эрсдэлд орсон дурсгалыг аюулгүй газарт шилжүүлэн байршуулах



1. Булган аймгийн Сайхан сумын нутагт орших Могойн шинэ усны гэрэлт хөшөө,



2. Сүхбаатар аймгийн Онгон сумын нутагт орших Таван толгойн хүн чулуун хөшөөд


- Холбогдох хууль, журам, шийдвэрийн хүрээнд нийт 2 дурсгалт газрын 5 ширхэг чулуун өвийг аюулгүй орчинд Соёлын өвийн үндэсний төвийн шинэ барилгын лабораторт шилжүүлэн хадгалсан. Үүнд, хүн чулуу 2ш, гэрэлт хөшөө хөшөөний суурь нийт 3 ширхэг болно.

БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.6-р арга хэмжээ.

Соёлын өвийг аврах, хамгаалах, ашиглах үндэсний сүлжээг төгөлдөржүүлэх, “Чулуун соёлын өв”, БСШУС-ын сайдын 2019 оны А/368 дугаар тушаал, төлөвлөгөөний 2.3.1, 2.3.2, 2.3.3, 2.3.6 дахь бүтээгдэхүүнийг хэрэгжүүлэх

- “Буган чулуун хөшөө, хүрлийн үеийн цогцолбор” өвийг Дэлхийн Өвд бүртгүүлэхтэй холбогдох нэмэлт засварыг бэлтгэн хүргүүлсэн.
- “Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөр-2020 төлөвлөгөөний 2.3.1, 2.3.2, 2.3.3, 2.3.6-д дурдсан дурсгалуудад хамгаалалтын хашаа, хайс барьж, танилцуулга байрлуулах арга зүй өгөх, хөшөө дурсгалыг хамгаалах хашаа барих болон түүний материалд тавигдах үндсэн шаардлагуудыг боловсруулав.
- Аялал жуулчлалын хөтөч тайлбарлагчдад зориулан чулуун соёлын өвийг тайлбарлах, соёлын өвийн мэдлэг боловсрол олгох агуулгаар баяжуулсан хөтчийн гарын авлага, ном болгон 500 ширхэг.



Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.6-р арга хэмжээ.

Соёлын өвийг аврах, хамгаалах, ашиглах үндэсний сүлжээг төгөлдөржүүлэх, “Чулуун соёлын өв”, БСШУС-ын сайдын 2019 оны А/368 дугаар тушаал, төлөвлөгөөний 2.3.1, 2.3.2, 2.3.3, 2.3.6 дахь бүтээгдэхүүнийг хэрэгжүүлэх

- Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутагт орших олонд Цогтын хадны бичээс гэж алдаршсан Дуутын хар чулууны бичигт үүссэн тосны бохирдлыг цэвэрлэв.



- Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаатай хамтран түүх, соёлын үл хөдлөх чулуун болон, дурсгалт уран барилгын хүрээлэн буй орчны гэмтлийн эрсдэлийг тогтоох бүтэн 1 жилийн харьцуулсан судалгааны хүрээнд тухай хамгаалалтын бүсэд орших Мэлхий хад, Шанхын хийд, Хархорумын нэгдүгээр бичээс зэрэг дурсгалуудад эрсдэлийн намрын хэмжилт, судалгааг хийлээ.



- Төв аймгийн Баянцагаан сумын нутагт Тосон бэлх, Эрчүүдийн адаг хэмээх газар орших Монголын үеийн орших 2 ширхэг хүн чулуунд хүрээлэн буй орчны анхан шатны тандалт, эрсдэлийн суурь судалгаа хийх арга зүй боловсруулах суурь ажлын эхлүүлэв.



ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ №3.1. “СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1-р арга хэмжээ.

Үнэлэх боломжгүй

“Соёлын биет бус өвийн үндэсний хөтөлбөр”-2020 төлөвлөгөөн дэх 2.1.2, 2.1.3 дахь арга хэмжээг хэрэгжүүлэх.


- 2020 оны 1 дүгээр сарын байдлаар Соёлын өвийн Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26.1 дүгээр зүйл, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан “Соёлын биет бус өвийн үзлэг хийх журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор 2020 оны 2 дугаар сарын 20-ноос 3 дугаар сарын 20-ны хугацаанд “Соёлын биет бус өвийн үзлэг хийх ажлын удирдамж”-ийг боловсруулан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар хүлээлгэн өгсөн.
- Монгол улсын хэмжээнд байгаа Соёлын биет бус өв болон өвлөн уламжлагчийн нэгдсэн бүртгэлийг тоон системд оруулах, өгөгдлийн дагуу мэдээлэл цуглуулах, цуглагдсан мэдээллийг богино хугацаанд нэгтгэн боловсруулахад зорилгоор www.ich.mongoluv.mn веб программыг шинэчлэн ашиглалтад оруулаад байна.



БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

■ Соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэлд 279


■ Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлд 83



Өвлөн уламжлагчийг 7 ай сав, өвлөн уламжлагчийн тоо, хувиар авч үзвэл:

- Эх хэл аман уламжлал, илэрхийллүүд 9 % нь буюу 817 хүн
- Ардын язгуур урлаг 46 % нь буюу 4187 хүн
- Үндэсний уламжлалт зан үйл, ёслол, баяр наадам 9,7 % буюу 881 хүн
- Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, зан үйл, 2,7 % буюу 252 хүн
- Уламжлалт арга ухаан 6,2 % буюу 566 хүн
- Мал маллах арга ухаан 1,7 буюу 156 хүн, 24 % нь буюу 2176 хүн
- Уламжлалт гар урлал 24% буюу 2176 хүн тус тус бүртгэгдсэн байна.

Өвлөн уламжлагчийн тоон дүн (өссөн үзүүлэлтээр)



Өвлөн уламжлагчийн 7 ай савд эзлэх хувь болон тооны үзүүлэлт





ХОЁРДУГААР ХЭСЭГ.

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

№	Үйлчилгээний төрөл	Арга хэмжээний нэр	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Гүйцэтгэл
1.	СОЁЛЫН ӨВИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ	ИРГЭНД ЧИГЛЭСЭН	1	1	100
		АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД ЧИГЛЭСЭН		1	100
	ДҮН		1	2	100 хувь



Гүйцэтгэлийн зорилт №.2.1.1. Төрийн үйлчилгээний нэр, төрөл: Иргэдэд соёлын өвийн мэдээлэл, лавлагааг, хялбар, хурдан шуурхай байдлаар зохион байгуулах арга хэлбэрийг хэрэгжүүлэх

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.1.1.1-р арга хэмжээ:

Соёлын өвийн талаар иргэдэд өгөх мэдээллийг цахим орчинд, хурдан шуурхай, чирэгдэлгүй хүргэх:



- Соёлын өвийн лавлагаа, мэдээллийг 4 иргэнд,
- Мэргэжил, арга зүйн зөвлөгөөг 16 иргэнд,
- Эд зүйлийн дүгнэлт, тодорхойлолтыг 6 иргэний 183 ширхэг эд зүйлд тус тус тодорхойлж үйлчлэв.
- Нийт 26 иргэнд үйлчилгээг үзүүлсэн байна. .




Гүйцэтгэлийн зорилт №2.2.1. Төрийн үйлчилгээний нэр, төрөл: Аж ахуйн нэгжид чиглэсэн үйлчилгээг сайжруулах

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 2.2.1.1-р арга хэмжээ:

Аж ахуйн нэгж, байгууллагад өгөх лавлагаа, мэдээллийг хурдан шуурхай, хүнд сурталгүй, авлигаас ангид хүргэх

- Лавлагаа мэдээлэл - 27 байгууллагад 35 удаа
- Сургалт арга зүйн - 8 байгууллага
- Мэргэжил арга зүйн зөвлөмж – 5 байгууллага
- Соёлын өвийн судалгаа судалгаа шинжилгээний ажил 5 байгууллага
- Ажлын хэсэгт 6 удаа
- Үзмэр шилжүүлсэн зэрэг ажил үйлчилгээг 2020 онд давхардсан тоогоор нийт 83 байгууллагад үзүүлжээ.





**ГУРАВДУГААР ХЭСЭГ. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

/ ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРЭГ, ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ /

№	Үндсэн чиг үүрэг	Зорилтын тоо	Төлөвлөгөөт арга хэмжээний тоо	Хэрэгжсэн арга хэмжээний тоо	Хэрэгжээгүй арга хэмжээний тоо	Гүйцэтгэл
1.	ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ №3.1.1. СОЁЛЫН БИЕТ ӨВИЙГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ	1	3	1		100
2.	ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ №3.1.2. СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙГ ТӨГӨЛДӨРЖҮҮЛЭХ	1	6	3	3 (санхүү, ковид-19)	90
3.	ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ №3.1.3. СОЁЛЫН ӨВИЙН ҮЗЛЭГ, ТООЛЛОГО ЗОХИОН БАЙГУУЛАХ	1	1(+1)	(+1)	1 (санхүү, ковид-19)	Үнэлэх боломжгүй, 95
4.	ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ №3.1.4. СОЁЛЫН ӨВИЙГ СУРТАЛЧЛАХ	1	1	1	1	100
Нийт		4	11(+1)	4	4	96,25 хувь

Гүйцэтгэлийн зорилт №3.1.1 Соёлын биет өвийг сэргээн засварлах.

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1.1-р арга хэмжээ.

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, археологийн олдвор эд зүйлийг бэхжүүлэх, сэргээн засварлах.

- 2020 онд 19 байгууллагын 49 ширхэг музейн үзмэр, 184 ширхэг археологийн олдвор, 3 хуулбар нийт 236 ширхэг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, археологийн олдворт хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын ажил хийсэн.



- металл эдлэл-7,
- баримлын төрөлд-7,
- модон эдлэл-8,
- уран зураг, танка-7,
- даавуу зөөлөн эдлэл-16,
- археологийн олдвор төрөл-5
- археологийн малтлага судалгаанаас илэрсэн-184

2020 онд дараах үзмэр, эд өлгийн зүйлийг сэргээн засварлаж эзэмшигч байгууллагад хүлээлгэн өгсөн байна.

- Говьсүмбэр аймгийн музей 4 үзмэр,
- Монголын театрын музей 2 ширхэг,
- Архангай аймгийн музей 4 ширхэг,
- Булган аймгийн музей 2 ширхэг үзмэр, 3 хуулбар
- Говь-Алтай аймгийн музей 3 ширхэг,
- Өмнөговь аймгийн музей 4 ширхэг,
- Төв аймгийн музей 3 ширхэг,
- Хархорум музей 5 ширхэг,
- Дүрслэх урлагийн музей 4 ширхэг,
- Орхон аймгийн музей 4 ширхэг,
- Өвөрхангай аймгийн музей 2 ширхэг,
- Баянхонгор аймгийн музей 2 ширхэг,
- Увс аймгийн музей 4 ширхэг
- Уран зургийн галерейн 3 ширхэг
- Монголын үндэсний музей 1 ширхэг, /Шийтэрийн олдвор/ 1 иж, Хоригийн олдвор 28 ширхэг,
- Монгол цэргийн музей 1 ширхэг,
- ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн 87 ширхэг,
- ШУА-ийн Археологийн хүрээлэн 68 ширхэг
- Үндэсний төв архив 1 ширхэг

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1.2-р арга хэмжээ

Шороон бумбагарын дурсгалт газрын ханын зургийн цэвэрлэгээ, судалгааны ажил.



- Газар дээр нь 2 удаагийн судалгаа хийсэн.
- Тухайн дурсгалын хадгалалтын бодит байдалд баримтжуулсан.
- Хүрээлэн буй орчны харьцангуй дулаан чийгшлийн хэмжээг олж тогтоосон.
- Чийгшлээс хамааралтай хөрсний эрдэс давсны шилжилтийг ажиглах судалгаа хийгдсэн.
- Дурсгалын гэмтэл удаашруулах арга хэмжээ авсан.
- Дурсгалын ханын зургийн өнгөнд хэмжилт хийсэн.
- Дурсгалын гэмтлийг зогсоох, ажиглах 6 ажлыг зохион байгуулав.

СӨУНБМСанд 2020 оны 2 удаагийн дурсгалт газрын орчны шинжилгээний 2 тайлан хадгаламжийн нэгж болж үүслээ.

ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1.3-р арга хэмжээ

Соёлын өвийг хамгаалахад химийн бодисын эрэлт хэрэгцээ, хэрэглээ, ашиглалтын сүлжээ бий болгох.

Дэлхий нийтэд тархаад буй “Ковид-19” цар тахлын нөлөөгөөр шинэ байр ашиглалтанд ороогүйн улмаас Соёлын өвийг хамгаалахад химийн бодисын эрэлт хэрэгцээ, хэрэглээ, ашиглалтын сүлжээ бий болгох ажил хэрэгжээгүй.

Монгол орны хэмжээнд худалдаанд байдаггүй соёлын биет өвийг сэргээн засварлах шаардлагатай бодис хэрэглэгдэхүүний зарим төрлүүдийг Цэцүүх ХХК, Грийн химистрий ХХК гэх мэт байгууллагаас Соёлын өвийн үндэсний төвийн заавар зөвлөмжийн дагуу хамтран ажиллаж худалдан авалт хийж захиалах боломжтой болсон. Химийн бодисын хор аюулын лавлах мэдээлэл MSDS-тэй сэргээн засварлагч судлаачид танилцсан.

Үнэлэх боломжгүй.

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.2.1-р арга хэмжээ.

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн 2018-2019 оны улсын тооллогын мөрөөр авах арга хэмжээ.

Тайлант хугацаанд 5 орон нутгийн музейд очиж ажиллахаар төлөвлөсөн ч дэлхий нийтэд тархсан covid-19 цар тахлын хорио цээрийн дэглэм нөхцөл байдлаас хамааран орон нутгийн томилолт явагдаагүй болно.

Нийт 44, орон нутаг судлах танхимын 262 ширхэг музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэлийн дэвтэр, тооллогын тайлан 40, цахим баримт нийт 350 ширхэг музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэлийн дэвтэр, тооллогын тайлан 61 ширхэгийг; Төрийн өмчийн 20 байгууллагын Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэлийн 44 дэвтэр, 21 тооллогын тайлан, 4 музейн цахим баримтыг тус тус СӨУНБМСанд хүлээн авч, санд хүлээн авсан цахим баримтаа нэг бүрчлэн шалгаж тогтоох ажлыг хийлээ.

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл буюу музейн үзмэр эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл “Register” программд эрх бүхий байгууллагуудын шийдвэрээр ерөнхий бүртгэлээс хасагдсан 32 дэсийн 101 үзмэрийн бүртгэлийг хасаж цэгцлэн, тухайн музейн хасаж акталсан тухай бүртгэлд шилжүүлэн, улсын тооллогын үр дүнгийн мөрөөр музейн цахим бүртгэлийг цэгцлэх ажлыг эхлүүлээд байна.

2018-19 оны Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлсийн Улсын тооллогоор бүртгэгдсэн REGISTER программын мэдээллийн сан бүхий www.register.mongoluv.mn сайтыг ашиглалтад оруулав. Одоогоор Цагдаагийн Ерөнхий газар албан хэрэглэгчийн эрхийг аваад байна.

Үнэлэх боломжгүй.

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.2.2-р арга хэмжээ.

Цаасан болон цахим суурьтай соёлын өвийн мэдээллийг Соёлын өвийн үндэсний төвийн шинэ байр руу нүүлгэн шилжүүлэх.



Дэлхий нийтэд тархсан Ковид-19 цар тахлын хорио цээрийн дэглэм нөхцөл байдлаас хамааран Соёлын өвийн үндэсний төвийн шинэ байр руу нүүлгэн шилжүүлэх ажил бүрэн хийгдээгүй болно. Өнөөдрийн байдлаар хэсэгчилсэн 2 удаагийн нүүлгэлт хийгдэж, тавилга, тоног төхөөрөмж болон СӨУНБМСанд хадгалагдаж байгаа 2008, 2012 оны улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогын Ерөнхий бүртгэлийн нийт 536 дэвтэр, 108 хадгаламжийн нэгж тайлан байснаас 484 ширхэг Ерөнхий бүртгэлийн дэвтэр болон 108 хадгаламжийн нэгж тайланг 10 хайрцагт хийж нэр, дугаар өгч, шинэ барилгад байршууллаа.

Үнэлэх боломжгүй.

ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ



Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.2.3-р арга хэмжээ.

Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн цаасан болон цахим архивыг төгөлдөржүүлэх.

№	Хамрагдсан байгууллага	Нэмэгдсэн дурсгал
1	Улс, аймгийн 28 музей	725 дэсийн 1101 ширхэг
2	ШУА-ийн Археологийн хүрээлэн, Палеонтологийн хүрээлэн, Монгол банкны Эрдэнэсийн сан, Ховд их сургууль	384 дэсийн 895 ширхэг
Нийт		1109 дэсийн 1996 ширхэг

-Археологийн олдвор 12 байгууллагад 448 дэсийн 1020 ширхэг нэмэгдсэн ба нийт дурсгалын 40 % эзлэж байна. Үүнээс 333 дэсийн 751 ширхэг нь Археологийн хүрээлэн, Ховд Их сургуульд нэмэгдсэн.

- Түүхийн дурсгал 19 музейд 200 дэсийн 382 ширхэг ба 18 %,
- Угсаатны зүйн дурсгал 20 музейд 167 дэсийн 242 ширхэг ба 15 %,
- Шашин шүтлэгийн дурсгал 11 музейд 110 дэсийн 145 ширхэг ба 10 %,
- Урлаг, уран сайхны дурсгал 13 музейд 94 дэсийн 112 ширхэг ба 9 %,
- Байгалийн түүхийн дурсгал 8 музей 89 дэсийн 93 ширхэг ба 8%-ийг тус тус эзлэж байна.



2018-2019 он тооллого
 -127264 дэс 27709 ширхэг үзмэр (Тоологдох)
 -126810 дэс 276077 ширхэг үзмэр (Тоологдсон)
 -105.659.865,196 ₮ (Үзмэрийн үнэ)

ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн цаасан болон цахим архивыг төгөлдөржүүлэх.

Шилжилт хөдөлгөөн:


д/д	Нэрс	Дотоодын үзэсгэлэнд оролцсон		Гадаадын үзэсгэлэнд оролцсон		Судалгаа, шинжилгээнд хамрагдсан		Сэргээн засварлагдсан		Дүн	
		дэс	тоо	дэс	тоо	дэс	тоо	дэс	тоо	дэс	тоо
1	Төрийн өмчийн 10 музей	1546	2123	25	40	1046	1323	36	251	4496	5907
2	Орон нутгийн өмчийн 20 музей	1709	2832	27	32	226	743	46	47	208	5870
3	Судалгаа, шинжилгээний байгууллага 2 (Археологи, Палеонтологийн хүрээлэн)	151	823	154	406			40	40	345	1959
4	Шашны байгууллага 1 (Гандантэгчинлэн хийд)	17	19					25	25	42	44
Нийт 33 байгууллага		3423	5797	206	478	1272	2066	147	363	4901	8704

Түүх, соёлын үл хөдлөх дурсгал. 14 аймагт 860 үл хөдлөх дурсгал шинээр бүртгэгдсэн.

№	Төрөл зүйл	Дурсгал илэрсэн аймаг	Дурсгалын тоо
1	Чулуун зэвсэг	Баянхонгор, Өмнөговь	2
2	Хадны зураг, бичгийн дурсгал	Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Ховд	46
3	Булш оршуулгын дурсгал	Архангай, Говь-Алтай, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Увс, Ховд, Хөвсгөл	753
4	Тахил тайлгын байгууламж	Баянхонгор, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Ховд, Увс, Хэнтий	19
5	Барилга архитектурын дурсгал	Дорноговь, Өвөрхангай, Өмнөговь, Хэнтий	11
6	Хөшөө дурсгал	Архангай, Өвөрхангай, Сүхбаатар, Ховд, Хэнтий	24
7	Палеонтологийн дурсгал	Баянхонгор, Дорноговь, Сүхбаатар	2
8	Үйлдвэрийн үл мөр хадгалсан дурсгал	Архангай, Өвөрхангай	3
Нийт			860

ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн цаасан болон цахим архивыг төгөлдөржүүлэх.



2020 оны байдлаар Соёлын өвийн үндэсний төвд: цаасан суурьтай **3080** хавтас баримт, цахим баримт **90ТВ** орчим, **3300** орчим тусгай тээгч бүхий баримт хадгалагдаж, **154930** соёлын өвийн цахим бүртгэл байна.

ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ	Цаасан суурьтай		Цахим				Тусгай тээгч	
	Нэгж баримт	Хавтас	Гэрэл зураг	Дуу, дүрс бичлэг	3D /GB/	Программ /дурсгалын дэс/	Оргинал хальс /ш/	CD, DVD /ш/
ХӨМРӨГ-А. ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛ	10756	1320	19.5 ТВ	3.28 ТВ	800 GB	135401	458	670
ХӨМРӨГ-В. ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛ	2108	1656	2.5 ТВ		1355 GB	9034	66	450
ХӨМРӨГ-С. СОЁЛЫН БИЕТ БУС ӨВ, ӨВЛӨН УЛАМЖЛАГЧ	1385	74	2.8 ТВ	56.8 ТВ		10495	1539	150
ХӨМРӨГ-Д. СОЁЛЫН ӨВИЙГ АВРАН ХАМГААЛАЛТ		5	10 GB					
ХӨМРӨГ- Е. СОЁЛЫН БИЕТ ӨВИЙН СЭРГЭЭН ЗАСВАРЛАЛТ	2915	25	2.9 ТВ					
НИЙТ	17164	3080	27.71 ТВ	60.08 ТВ	2155 GB	154930	2063	1270

ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.2.4-р арга хэмжээ.

Соёлын биет болон биет бус өвийн дүрс бичлэг, гэрэл зургийн мэдээллийн сан бүрдүүлэх


2020 онд нийт түүх, соёлын хосгүй үнэт 274 үзмэрийн гэрэл зураг, дүрс бичлэг авах ажил хийсэн.

Монгол төрийн түүхийн музейд 259 ширхэг хосгүй үнэт дурсгал зүйлийн 46.56 GB хэмжээтэй, 3:50:12 цагийн дүрс бичлэгээр,

Гандантэгчэнлин хийдийн 15 бурхадын 4 цаг 52 мин 57 сек-ийн дүрс бичлэг хийж, СӨУНБМСанд архивлан хадгалав

2015 оноос хойш үе шаттай хэрэгжүүлсэн уг ажлын үр дүнд 778 хосгүй үнэт дурсгалт зүйлээс 680 дурсгалын дүрс бичлэгээр баримтжуулж нийт 2.6 ТВ хар дүрс хийгээд байна.

ТҮҮХ, СОЁЛЫН ХОСГҮЙ ҮНЭТ
ДУРСГАЛЫГ ДҮРС БИЧЛЭГЭЭР
БАРИМТЖУУЛАХ АЖИЛ





Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.2.5-р арга хэмжээ.

Соёлын өвийн мэдээллийн сангийн цахим сүлжээ байгуулан ажиллах, байгууллага, олон нийтэд, мэдээллийг түгээх.


1. Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэлийн Register болон RCH2.0 програмуудад системийн шинэчлэл хийгдсэн.
2. www.register.mongoluv.mn системээр эрх бүхий байгууллагуудыг мэдээллээр хангах боломжийг бүрдүүлсэн.
3. УНБМСангийн Archive программыг дотооддоо хэрэглээнд нэвтрүүлэх ажил хийгдэж эхэлсэн.
4. Говь-Алтай аймгийн соёлын төвийн ажилтнуудад анхан шатны байдлаар мэргэжил, арга зүйн зөвлөмжийг цахимаар хүргүүлсэн.
5. 7 байгууллагын 13 газарт Соёлын өвийн бүртгэлийн Улсын код шинээр олгож, Register бүртгэлийн программд Админ эрхийг нээсэн.
6. Соёлын өвийн цахим мэдээллийн нэгдсэн системийн (E-SOYLIIN OV) танилцуулга, бүтэц, загварын төсөл боловсруулагдсан.
7. Холбогдох байгууллагууд хэрэглэгчийн эрхээр нэвтрэх GIS-д суурилсан WEBMAP-ийн эхний хувилбарыг боловсруулагдаж түүх, соёлын үл хөдлөх дурсгалын мэдээлэл өргөн хүрээтэй болж, хяналт сайжрах боломж бүрдсэн.

Цахим орчинд соёлыг түгээе аяны хүрээд: 127977 хүн соёлын өвийн мэдээлэлд хандалт хийж, мэдээлэл хүлээн авав.



Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.2.6-р арга хэмжээ.

Улаанбаатар хотод байрлах улсын музейн гадаад, дотоод орчны хадгалалт хамгаалалт ба соёлын өвийн БМСангийн бүрдүүлэлтэд арга зүйн зөвлөгөө өгөх.



Ковид-19 цар тахлын хорио цээрийн дэглэмээс шалтгаалан 7 музейд ажиллахаас 4 музейд ажиллаж орчны судалгаа хийж, зөвлөгөө өгч ажиллав.

Монголын музейн барилгуудын хувьд стандартын бус ихэвчлэн дэлгүүр хоршоо, агуулах, сүм хийд байдлаар ашиглагдаж байсан барилгад байрладаг учир зориулалтын агааржуулалт байхгүй, хөрсний эвдрэлтэй, эрсдэлийн үнэлгээ хийлгээгүй, насжилт өндөр зэрэг олон шалтгаанаас болж үзмэр хадгалахад тохиромжтой бус нөхцөл үүсээд байна.

Дээрх музейн барилгуудын орчин нөхцөл, барилгын онцлогт тохирсон хадгалалт хамгаалалтын орчин нөхцөлийг бүрдүүлэн ажиллахыг зорьж орчны судалгаа хийсэн нь үр дүнтэй хувилбар болж байна.



Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.3.1-р арга хэмжээ.

“Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого-2020” зохион байгуулахад хамтран оролцох


Ковид-19 цар тахлын нөлөөгөөр арга хэмжээг зохион байгуулах шийдвэр гараагүй, санхүүжилт олгогдоогүй.

Бэлтгэл ажил бүрэн хангагдсан.

- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг тооллого зохион байгуулах ажлын удирдамж гарсан.

- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг тооллого зохион байгуулах арга зүйгээр хангах 1 ном, 3 гарын авлага хэвлэгдсэн.


- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын цахим бүртгэлийн RICH программ хангамж хөгжүүлэлт шинэчлэлттэй холбогдуулан RICH-3 программд бүртгэлтэй үл хөдлөх дурсгалын бүртгэлүүдийг RICH-4 хувилбар руу хөрвүүлж улсын үзлэг, тооллогод ашиглахад бэлэн болгосон.



4101-0001-4-001

Цифр	Хамаарах утга
1-2	Аймгийн код
3-4	Сумын код
5-8	Суман дахь дурсгалт газрын дэс дугаар
9	Төрөл зүйлийн ерөнхий ангилал
10-12	Тухайн дурсгал доторх нэгж дурсгалын дэс дугаар

ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ҮЗЛЭГ, ТООЛЛОГОД ХАМРАГДСАН НИЙТ ДУРСГАЛЫН ТООН, ХУВИЙГ ХАРУУЛСАН БАЙДАЛ



➤ RICH 3.0 програм хангамжид нийт Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн 330 сумын нутаг дахь 9537 дурсгалт газрын 86157 үл хөдлөх дурсгалыг хамрагдсан.

Үнэлэх боломжгүй

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.3.1-р арга хэмжээ. (+1) Музейн үзмэрийн тооллогынмөрөөр авах арга хэмжээ
“Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого-2020” зохион байгуулахад хамтран оролцох

Гандантэгчэнлин хийдийн улсын тооллогын ажил 95%-ийн гүйцэтгэлтэй байна.



Нийт тоологдох 8333 дэсийн 46064 ширхэг бурхан шүтээн, эд өлгийн зүйлсээс урьдчилсан дүнгээр 8253 дэсийн 45819 ширхэг бурхан шүтээн тоологдоод байна.

- Дутагдсан 4
- Галд шатсан 1
- ҮАБЗ -11



Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.4.1-р арга хэмжээ.

Соёлын өвийг сурталчлах, мэдлэг олгох.



1. Соёл, Урлагийн Их Сургуулиас эрхлэн гаргаж буй “Соёл, урлагийн тайлбар толь” цувралын “Соёлын өв” ботийг бүтээх Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж 185 үл хөдлөх дурсгал, 362 СББӨ, 1000 аруй гэрэл зурган мэдээллийг бэлтгэн хүргүүлсэн.
2. Тус Үндэсний төвөөс эрхлэн гаргадаг “Соёлын өвийн мэдээ, мэдээлэл” сэтгүүлийн агуулгыг урьдчилсан байдлаар:
 - Соёлын биет ба биет бус өвийн бүртгэл баримтжуулалт, Сэргээн засварлалт чиглэлээр хийгдсэн ажлын тухай,
 - Соёлын өвийн танин мэдэхүй гэсэн чиглэлээр сэтгүүлийн төлөвлөсөн.
 - Дэлхий нийтэд Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахал дэгдсэнээс болж сэтгүүл хэвлэх санхүүжилт зогссон тул дээрх ажил хийгдээгүй.



Нэмэлтээр:

- Уулзалт, арга хэмжээ, үзэсгэлэн-5
- Телевизийн нэвтрүүлэг, ярилцлага-4
- Эрхэлж гаргасан ном, хэвлэл-7

Судалгааны өгүүлэл, илтгэлээр соёлын өвийг сурталчилсан байдал-10



/ ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ/

2 ажлын байранд сонгон шалгаруулалт ил тод зарласан.

2 удаагийн сургалт зохион байгуулсан.

63 төрлийн 83 хүн бүхий орон тоо, цалингийн санг агуулсан санал бэлтгэж боловсруулсан.

Нийт 3 ажилтан докторантурт, 3 ажилтан магистрантурт суралцаж байна.

Төрийн албан хаагчийн ёс зүй, Төрийн албан хаагчийн хандлага харилцааны тодорхой түвшинд хүрсэн.

3 ажилтан ОУ-ын сургалтад хамрагдаж мэдлэгээ дээшлүүлсэн.

Азийн сангийн мастер багш Т.Оюундарьтай гэрээ хийн Төрийн албаны ёс зүй”, “Төрийн албан хаагчийн хандлага, харилцаа”, “Төрийн албан хаагчийн манлайлал”, “Төрийн албан хэрэг хөтлөлт”, “Зөрчил стрессийг удирдах”, “Хүний нөөцийн удирдлагуудад зориулсан сургалт” зэрэг сэдвүүдээр 6 удаагийн 12 цагийн сургалтыг нийт албан хаагчдад зохион явууллаа.

Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилт, сахилга дэг журмын хэрэгжилт тус тус хангадсан. Нийт 2 удаагийн хяналт шалгалт хийгдсэн

Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийгдсэн /Сэргээн засварлах газарт/

1 ажлын байр хэвийн, 4 ажлын байр хөдөлмөрийн хортой буюу 3,1-р зэрэг, 1 ажлын байр хортой буюу 3-р зэрэг, 1 ажлын байр хөдөлмөрийн нөхцөлийн 4-р зэргийн хортой хэмжээнд үнэлэгдсэн.

Авлигатай тэнцэх газарт 2 удаагийн зөвлөмж хүссэн албан бичиг хүргүүлсэн. Шинээр газрын даргад томилогдсон 2 албан тушаалтны хөрөнгө орлогын мэдээллийг АТГ-т хүргүүлсэн.

Онцгой байдал, гал түймэр, гамшигтай тэмцэх, бэлэн байдлын төлөвлөгөө, үйл ажиллагааны түвшин сайжирсан. Галын аюулгүй байдлын хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт сайн.


“Ковид-19” буюу коронавирус халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар 12 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан ажил маш сайн.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний тодотгол хийсэн.

Албан өрөөний цахилгаан хэрэгсэл ашиглалт аюулгүй байдал сайн.


Тус байгууллагын нийт албан хаагчид Онцгой байдлын ерөнхий газрын гамшгаас хамгаалах мэргэжил арга зүйн төвд 2020 оны 10 сард хамгаас хамгаалах 4 төрлийн үзүүлэх сургалтад хамрагдсан.

2016-2020 оны төсвийн танилцуулга




Он	Төсвийн санал	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл
2016	450,700,000.0	377,565,100.0	368,074,809.0
2017	550,056,200.0	414,520,100.0	413,433,906.70
2018	568,317,900.0	457,480,500.0	442,844,629.33
2019	987,922,800.0	637,337,700.0	539,561,285.07
2020	1,403,439,400.0	698,742,500.0	581,626,752.0
2021	1,451,527,700.0	687,184,300.0	

2016-2020 оны цалингийн мэдээлэл




Он	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
2016	280,333,700.0	280,317,334.0	16,366.0
2017	277,530,400.0	277,530,400.0	0
2018	283,958,900.0	270,893,648.0	13,065,252.0
2019	463,636,600.0	378,768,221.0	84,868,379.0
2020	539,609,600.0	438,819,798.3	100,789,801.7

2016-2020 оны түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах зардал




Он	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
2016	17,767,400.0	9,703,423.0	8,063,977.0
2017	53,925,700.0	53,423,782.0	501,918.0
2018	54,600,000.0	54,554,320.0	45,680.0
2019	47,200,000.0	47,156,544.0	43,456.0
2020	8,913,500.0	8,913,500.0	0

2016-2020 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр



	Нийт төсөл хөтөлбөр	Гадны төсөл хөтөрлбөр / Юнеско болон бусад ОУ-ын байгууллага	Дотоодын төсөл хөтөлбөр / Дээд шатны байгууллага/
2016	258,920,057.4	214,705,238.0	44,214,819.4
2017	128,719,495.0	120,669,495.0	8,050,000.0
2018	126,522,890.0	85,093,890.0	41,429,000.0
2019	217,608,661.0	187,868,661.0	29,740,000.0
2020	181,837,484.8	93,190,484.8	88,647,000.0

Соёлын өвийн үндэсний төвийн үйл ажиллагааны стратеги төлөвлөлт 2015-2050 он



ДУГНЭЛТ

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ Г.ЭНХБАТЫН 2020 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН НЭГДСЭН ДҮН



№	Хэсэг	Зорилтын тоо	2020 оны төлөвлөгөөт арга хэмжээний тоо	2020 онд хэрэгжсэн арга хэмжээний тоо	Үнэлэх боломжгүй арга хэмжээний тоо	Дундаж	
1.	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ	3	8	4	4	97,5	
2.	ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ	1	2	2		100	
3.	ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ	ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРЭГ	4	12(11+1)	8(7+1)	4	96,25
		ХУУЛИАР НИЙТЛЭГ ОЛГОСОН ЧИН ҮҮРЭГ	8	8	8		96,25
Нийт		16	30(29+1)	22	8	97.5	

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА